



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/264


Ховд

Шүүхийн шийдвэртэй өр барагдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 5/07 дугаар тогтоол, аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 153/ШШ2021/00324, 153/ШШ2021/00325, 153/ШШ2021/00326, 153/ШШ2021/00327 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Төсөвт байгууллагуудад дулаан халаалтын үйлчилгээг үзүүлж буй хувийн хэвшлийн байгууллагуудын эрх бүхий байгууллагаас баталсан төлбөрийн үнэлгээгээр тооцсон халаалтын хөлс болон дулаан ашиглагч төсөвт байгууллагуудын жил бүрийн халаалтын батлагдсан төсвийн зөрүүгээс үүссэн өрийг төлүүлэх тухай Ховд аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн төгрөг 230,320,658 төгрөг (хоёр зуун гучин сая гурван зуун хорин мянга зургаан зуун тавин найм)-ийг хавсралтаар баталж халаалтын өрийг барагдуулахаар зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 230,320,658 төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд зохицуулалт хийж, 2022 онд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1382



Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 15-ны өдрийн  
А/264 дугаар захирамжийн  
хавсралт

## БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖАГСААЛТ

Д/д	Хүлээн авах байгууллагын нэр	Шүүхийн шийдвэрийн он сар, өдөр, дугаар	Төлбөр тооцогдох он, сар	Нийт дүн (төгрөгөөр)
1.	Эрдэнэбүрэн сумын Соёлын төв	2021.06.22 №153/ШШ2021/00325	2019, 2020	23494854.00
2.	Эрдэнэбүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль	2021.06.22 №153/ШШ2021/00327	2019, 2020	132203584.00
3.	Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газар	2021.06.22 №153/ШШ2021/00324	2019, 2020	65241664.00
4.	Эрдэнэбүрэн сумын Хүүхдийн цэцэрлэг	2021.06.22 №153/ШШ2021/00326	2019, 2020	9380556.00
Дүн				230320658.00

-оОо-